



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/119/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 206

танай _____ ны № _____ т

БУЛГАН СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Ч.БАЛДАНДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Булган сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолын нэмэлт өөрчлөлтийн дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны XII/01 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын XVII/03 дугаар тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 101.7 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

006020471

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Булган сумын Засаг даргын тамгын газар нь 1 хөтөлбөр 9 зориулалт арга хэмжээний хүрээнд 1,728.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 1,704.1 сая төгрөгийг зарцуулж 24.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ

Хоёр. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	39,196,829.0	63,059,772.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,457,636,598.5	3,941,462,368.0
	Нийт хөрөнгийн дүн	3,496,833,427.5	4,004,522,140.0
	Нийт өр төлбөрийн дүн	4,470,820.3	4,470,820.3
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,492,362,607.1	4,000,051,319.6
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,496,833,427.5	4,004,522,139.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,805,074,807.4	2,887,746,426.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,877,262,218.6	2,379,757,713.5
	Үйл ажиллагааны үр дүн	(72,187,411.2)	507,988,712.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	1,785,228.9	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(73,972,640.1)	507,988,712.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,266,635,247.3	3,492,062,607.1
	Тайлант оны үр дүн	225,727,359.9	507,988,712.5
	Эцсийн үлдэгдэл	3,492,362,607.1	4,000,051,319.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,805,074,807.4	2,397,891,352.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,589,502,016.4	2,315,847,852.0
	Үйл ажиллагааны ЦМГ	215,572,791.0	82,043,500.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(215,272,791.0)	(82,043,500.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	300,000.0	(0.0)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	300,000.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	300,000.0	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	1,704,064,095.2
	Урсгал зардал	-	1,634,130,295.2
	Хөрөнгийн зардал	-	69,933,800.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	1,728,964,895.0
	Орон нутгийн төсвөөс	-	1,728,964,895.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	-

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 310,355.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Нэг албан хаагчид 855.0 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон нь УСНББОУС-1, толилуулга батламж мэдэгдэл,
- Тайлан бүртгэлд 309,674.9 мянган төгрөгийн газрыг тусгаагүй УСНББОУС-17, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 13,228.1 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 10,244.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 4 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 13,228.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 21,014.6 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

3.2 Албан шаардлага

1. Байгууллагын аварга ажилтан 2022 оны 5, 2023 оны 6 албан хаагчид цалингийн сангаас нэг сарын үндсэн цалингаар нийт 10,244.5 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.6-д “*Төсвийг зориулалт бусаар зарцуулсан*”

3.3 Зөвлөмж

1. Төрийн үйлчилгээний албан хаагчийг үнэлж олгох үр дүнгийн урамшууллын журам батлаагүй нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтын 2.6, ангилал болон эрх үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн үйлчилгээний албан хаагчийг үнэлж олгох үр дүнгийн урамшууллын журам баталж албан хаагчдыг үнэлэх

2. Байгууллагын эзэмшилд бүртгэлтэй 33 нэр төрлийн 54,217.6 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг дахин үнэлээгүй нь Төрийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Аймгийн ИТХ-ын 2014 оны 17 дугаар тогтоолын хавсралтын 6.1, 6.2, 2018 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 2.4, 2.5-д заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн ИТХ-ын 2014 оны 17 дугаар тогтоолын хавсралтын 6.1, 6.2, 2018 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын 2.4, 2.5-д заасны дагуу дахин үнэлэх, актлах ажлыг зохион байгуулах.

3.3Д-ын нөөц хөрөнгөнөөс захирамжгүйгээр 2,983.6 мянган төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 4.1-д заасныг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 4.1-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллах

4. Санхүүгийн тайланг хуулийн цаглаварт хугацаанд ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өглөө.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Булган сум ЗДТГ	2	310.5	2	310.5	0	0	2	310.5	0.0	0.0	0.0	0.0
Дүн	2	310.5	2	310.5	0	0	2	310.5	0.0	0.0	0.0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Булган сум ЗДТГ	5	13.2	0	-	1	10.2	4	3.0	0	-	0	-
Дүн	5	13.2	0	-	1	10.2	4	3.0	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Булган сум ЗДТГ	1	1,510.2			1	1,510.2	0	0
Дүн	1	1,510.2			1	1,510.2	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Булган сум ЗДТГ	1	29.6	0	0	1	29.6	0	0
Дүн	1	29.6	0	0	1	29.6	0	0
Нийт дүн	2	1,539.8	0	-	2	1,539.8	0	0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			